



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 18 өдөр

Дугаар А/167-

Бат-Өлзий сум

Шууд гэрээ байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Засгийн газрын 2021 оны “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 124 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Бат-Өлзий сумын Бүрэгтий багийн төвийг тогтой болгох ажлыг “Мөнхийн-Илч гэрэл” хязгаарлагдмал хариуцлагатай компанитай шууд гэрээ байгуулах аргаар гүйцэтгүүлсүгэй.

2. “Мөнхийн-Илч гэрэл” хязгаарлагдмал хариуцлагатай компанитай гэрээ байгуулж, ашиглалтын явцад хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

3. Зардалд шаардагдах 17,000,000 (арван долоон сая) төгрөгийг гэрээний дагуу зарцуулахыг Санхүүгийн албаны нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.

4. Санхүүжилтээ авахад шаардагдах материалыг бүрдүүлэн авч төлбөр тооцоог хийж гүйцэтгэхийг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН